

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 5 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 151

Улаанбаатар хот

Г “Монголрейтинг сервис” ХХК-д зэрэглэл 7
тогтоох эрх олгох, үйл ажиллагааг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан “Зэрэглэл тогтоох этгээдэд эрх олгох, үйл ажиллагааг бүртгэх журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монголрейтинг сервис” ХХК-ийн зэрэглэл тогтоох үйл ажиллагааг бүртгэж, зэрэглэл тогтоох эрхийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

2. Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмж болох “Зэрэглэл тогтоох үйл ажиллагааны үндсэн дүрэм буюу ёс зүйн дүрэм”, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан “Зэрэглэл тогтоох этгээдэд эрх олгох, үйл ажиллагааг бүртгэх журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах, Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Монголрейтинг сервис” ХХК /Ц.Батбилэг/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдснаас хойш ажлын 15 хоногийн дотор компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрэмд “Хуулийн этгээдэд зэрэглэл тогтоох үйл ажиллагааг явуулах” гэж тусган Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, Хороонд зохих баримтыг ирүүлэхийг “Монголрейтинг сервис” ХХК /Ц.Батбилэг/-д үүрэг болгосугай.

4. Энэ тухай Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдэгдэж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН